

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр, Баасан гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 2-4

---

*1.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай* 2-4

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн  
анхдугаар чуулганы Төсвийн байнгын хорооны  
2024 оны 7 дугаар сарын 05-ны өдөр /Баасан гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 21 гишүүн ирж, 84.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 53 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Болормаа, Х.Булгантуяа, Т.Доржханд.

**Нэг.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Дэд хорооны бүрэлдэхүүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга, О.Амгаланбаатар, Г.Дамдинням нар үг хэлэв.

Хуралдаан даргалагч Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хойшлуулж, хуралдаан түр завсарлаж байгааг мэдэгдэв./15:03/

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 10 минут үргэлжилж, 25 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 84.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 03 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ц.ДАВААСҮРЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр,  
Баасан гараг

Төрийн ордон “Үндсэн хууль” танхим  
14 цаг 53 минут.

### ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ц.Даваасүрэн:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье. Төсвийн байнгын хорооны гишүүнээр сонгогдсон гишүүддээ баяр хүргэе.

Өнөөдрийн Төсвийн байнгын хорооны хуралдааны ирц, ирц хэд вэ? Ирцээ гаргачих. Айн хэдэн хувь уу? 25-аас 20 чинь хэдэн хувь уу?

25-аас 20 гишүүн ирсэн байна. 80 хувийн ирцтэй байгаа учраас хуралдааныг нээснийг мэдэгдье. Би ирсэн гишүүдийг танилцуулъя.

Пүрэвбаатарын Мөнхтулга, Ганзоригийн Тэмүүлэн. Тэр тойрог хэрэг байхгүй байлгүй дээ. Ганзоригийн Тэмүүлэн, Очирбатын Амгаланбаатар, Загджавын Мэндсайхан. Энэ их царгиад дуу нь. Энэний дууг нь жоохон яаж болохгүй юу? Царгиад байх шиг байна тээ.

Батжаргалын Заяабал, Баттогтохын Чойжилсүрэн, Тилеуханы Аубакир, Дамбын Батлут, Цэрэнпилийн Даваасүрэн, Жигжидийн Батжаргал, Далайн Батбаяр, Гонгорын Дамдинням байна шүү дээ. Энийг тэмдэглэ. Дамдиннямыг тэмдэглэчих. Дамдинням, Чинбатын Ундрэм, Гомбын Ганбаатар, Хүрэлбаатарын Булгантуяа? Алга. Хассуурийн Ганхуяг, Норовын Алтанхуяг, Ринчиндоржийн Батболд, Жадамбын Баясгалан, Пүрэвжавын Ганзориг, Бадамдоржийн Пунсалмаа, Даваахүүгийн Пүрэвдаваа гэсэн гишүүд өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Би хуралдааны хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар нэг асуудал хэлэлцэнэ.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнийг байгуулах ёстой. Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүн байна уу? Нэг үү? Хэн нь вэ? Пүрэвбаатарын Мөнхтулга. Өөр санал, үгтэй гишүүн байна уу? Айн?

**Н.Алтанхуяг:** Хэдэн хүнтэй байгаа юм?

**Ц.Даваасүрэн:** Юу?

**Н.Алтанхуяг:** Хэдэн хүн байгаа юм? Зарлагын хяналтын дэд хороо?

**Ц.Даваасүрэн:** 11 хүнтэй байгуулахгүй бол болохгүй юм байна. 50 хувиас дээш байж болохгүй болохоор. Үгүй ээ нөгөө квотоороо. 6 нь Монгол Ардын нам, 5 нь бусад улс төрийн хүчин. Би болохоор Ардчилсан намаас 2, нөгөөдхөөс 1, 1. Ингээд 5. Ардчилсан намын 2-ын 1 нь дарга.

Үгүй ээ тэгэхээр 12 болчихоор болохгүй болчихоод байна.

**Н.Алтанхуяг:** Үгүй ээ Даваасүрэн гишүүн манайх цөөнх л даргалж байхаар л хийх хэрэгтэй. Шийдвэр нь ч гэсэн тэгж гарахаар хийх хэрэгтэй шүү дээ. Тэгэхгүй бол утгагүй шүү дээ.

**Ц.Даваасүрэн:** Хуралдааныхаа дэгийн дагуу явъя. Үг хэлэх, санал хэлэх улсууд нь гараа өргөчих. Санал хэлэх улсууд гараа өргөчих. Мөнхтулга, Амгаланбаатар хоёр.

Мөнхтулга. Мөнхтулгын микрофоныг өгье.

**П.Мөнхтулга:** Юун дээр 12 чинь угаасаа 25 гишүүн байгаа. 50 хувь дотроо байгаа байхгүй юу. Тэгэхээр 12-оороо яваад, тэртээ тэргүй Хяналтын хороо юм чинь тэр дээр зөрөлдөх юмнууд

зөндөө гарна шүү дээ. Тэгэхээр хуучин өгсөн тоогоороо явахгүй бол гишүүдийн, нэг гишүүний саналыг байхгүй болгочхож байна гэсэн үг шүү дээ. Энэ чинь Хяналтын хороо юм чинь. Тэх болчихсон, 12-оороо явъя гэсэн санал байна.

**Ц.Даваасүрэн:** Дараагийнх нь хэн байлаа? Амгаланбаатарын микрофоныг өгье. Гишүүний.

**О.Амгаланбаатар:** Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. 11-ээрээ явж болно. Гэхдээ 11-ээрээ явахдаа 6 биш, хэрвээ олонхоос нь 6 биш, Монгол ардын намаасаа 5-ыг оруулаад, Ардчилсан намаас тэр 3-ыг оруулаад, наана нь тэр бусад намаасаа 3-ыг нь оруулаад явж болж байна шүү дээ. Заавал энэ чинь Ардын намаас 6 гэдгээ бариад явах юм бол дараа нь асуудлаа ч ярих дээр ч болохгүй юм биш үү? Дарга нь тэртээ тэргүй Ардчилсан намаас тавина гэж ярьж байгаа бол, цөөнхдөө яаж байгаа бол.

**Ц.Даваасүрэн:** Квотоороо л гээд л тогтчихсон юм байна л даа.

**О.Амгаланбаатар:** Квотоороо юм бол Ардчилсан нам яахаараа 2 байх ёстой гэж? Та чинь тоо сайн мэдэх байлгүй дээ. Наад пропорцоор нь гэж яриад байх юм. Тэгэх юм бол тэрүүгээр нь бодоод үзэхээр яахаараа 2 байх ёстой юм?

**Ц.Даваасүрэн:** Тэгэхээр чинь нөгөөдүүл нь юмгүй үлдчих гээд байна шүү дээ.

**О.Амгаланбаатар:** Үгүй ээ тэгвэл яахаараа Ардчилсан намд тэгвэл хувиараа тооцоод үзвэл 2 байх ёстой гэж? Тийм харин тийм. Тэгэхээр чинь, тэгээд л тэр хувиар нь л бодчихооч.

**Ц.Даваасүрэн:** Жижиг намуудыг 1, 1-ийг өгөхөөр тэр нь эвдэрчхээд байхгүй юу. Миний эрх мэдлээс давчих гээд байна. Нөгөө пропорц нь өөрчлөгдөөд. Хэрвээ саяын хэлснээр би

хэллээ шүү дээ. Ингээд 6 нь бол квотоороо Монгол Ардын нам юм байна. 5-аас 3 нь болохоор нөгөө хоёртоо өгөөд, 2 нь Ардчилсан намын 2. Ардчилсан намын 2-ын 1 нь дарга. Тэгээд боломжгүй гэвэл тэгээд өнөөдрийн хурлыг завсарлая.

Тийм, тэгэх үү? Тэгвэл завсарлачих уу? Тийм. Өөрөөр ямар ч боломжгүй юм байна.

6, 6 гэхээр наадах чинь болохгүй болчихно. Угаасаа энэ 20-иод жил тэгж явж ирчхээд энэ дээр орж ирэнгүүтээ тэгээд л хоёрын хооронд юм яриад байх хэрэггүй шүү дээ.

Айн? Харин тэгэхээр тэнцчихээд байдаг юм байна лээ. Хуучин бид нар 21-ээр явдаг байсан учраас ямар нэгэн асуудал гардаггүй байсан байхгүй юу. Сая хорооны тоо нэмчхэнгүүт тийм болчихоод байгаа юм байна л даа. Айн? Харин тийм 5-ыг нь хувааж өгч байгаа нь тэр байхгүй юу.

Тэгэхээр чинь 1 нь үлдчих гээд байна шүү дээ нөгөө 3-ын чинь. Айн? Болохгүй л дээ. Нэг бол тэгээд бүлгийнхээ дарга нарын хооронд ярьчихаад ороод ир. Тэгэхгүй бол би байгаа хэмжээндээ, эрх мэдлийнхээ хүрээнд л ярина шүү дээ. Тэгээд өнгөрсөн практик нь тийм байсан учраас л би тэгээд байна шүү дээ.

Бид нар чинь үндсэндээ 9 удаагийн парламентад 8-д нь тэгээд явчихсан л гэсэн үг байхгүй юу даа. Тэгээд орж ирэнгүүтээ өөрчлөх гээд юугаа хийх вэ дээ.

Дамдиннямын микрофоныг өгье.

**Г.Дамдинням:** Энэ жсоохон зөөлөн ярихгүй бол аягүй шуугиантай байгаа юм байна. Юу яая даа дарга аа, нэгэнт ийм зарчмын зөрүүтэй байр суурь мэдээж улс төрийн хүчин бүгдээрээ орё л гэж байгаа байлгүй. Тэгээд угаасаа төсөв баталж байсан хүмүүс бол манай

*Алтанхуяг гишүүн бүгдээрээ л мэдэж байгаа байх. Төсвийн зарлагын дэд хороо чинь бас их чухал дэд хороо. Хугацаатай байдаг, шийдвэр нь хугацаатай гардаг. Та нар бас харна биз.*

*Тэгээд энд тэнцэж болохгүй. Тэнцэх магадлалтайгаар бид нар тоог нь хийж болохгүй. Заавал өөр тоо байх ёстой. Тэгж байж шийдэл гарна. Тэр хэн нь илүү байх биш. Ер нь 11, эсвэл 13 ч юм уу заавал ийм. Тийм болохгүй. Хууль нь өөрөө 12-оос доош байхад. Хууль зөрччих гээд байна.*

*Тэгэхээр хэдүүлээ юу яая даа даргаа ийм горимын санал байна. Энэ намын бүлгүүд дотроо ярилцаад шийдлээ Байнгын хороон дээр оруулж ирэх чиглэл өгөөд та завсарлачихвал яасан юм? Тийм.*

**Ц.Даваасүрэн:** *Тэгэх үү айн? Бүлэг дээрээ яриад тэгээд ороод ир. Манайхны хуучин тогтсон юу нь тийм л юм байна. Хуучин яг тэгж явж л ирсэн юм байна. Би тэрүүгээр нь л сая танилцуулж байгаа юм. Уг нь 13 байвал аятайхан.*

*Гэтэл хууль зөрччихөөд байна. 12 болгочихоор. Тэгээд наадах чинь санал шийдэж чаддаггүй болчихно. Тэгэх үү? Тийм, дахиж ярьчихаад ороод ир.*

*Хурал үргэлжилж байгаа шүү. Хурал үргэлжилж байгаа. Түр завсарлая.*

15.03 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР